

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-8</i>

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	3-8
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 08 дугаар сарын 15-ны
өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 39 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Бум-Очир, Д.Ганмаа;
Тасалсан: Ж.Батсуурь, Б.Жавхлан, Д.Жаргалсайхан.

Б.Баярбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 0
Бүгд: 8
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт С.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Б.Баярбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 1
Бүгд: 8
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
13 цаг 39 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Хурлыг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирц хүрсэн байгаа.

Өнөөдөр хэлэлцэх асуудал. Энэ чөлөөтэй байгаа гишүүдээ танилцуулчихъя тийм ээ. Бум-Очир гишүүн орон нутагт томилолттой. Галбадрах гишүүн байж байгаад Байнгын хорооноос гарсан. Ганмаа гишүүн гадаадад томилолттой явж байгаа. Өнөөдөр бас Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод Лүндэг гишүүн гараад, оронд нь Сангийн сайд Болдын Жавхлан гишүүн орж ирсэн.

Ингээд Байнгын хорооны бүрэлдэхүүн 13 хүний тоотой хэвээрээ ингээд явж байна.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна. Хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг манай Байнгын хороо хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу?

Байхгүй бол хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн саналыг хураая.

Рэгдэл дарга саналаа өгөх үү. Рэгдэл гишүүн.

Төхөөрөмж дээрээ хурааж үзэх үү, хэдүүлээ. Тэгвэл 1 төхөөрөмжөөрөө нэг санал хураалтыг, эхлээд туршилтын санал хураалтыг явуулаадахъя. Туршилтын санал хураалт.

Рэгдэл гишүүн, Хэрлэн гишүүн 2 төхөөрөмж болсонгүй юу, хуруугаа уншаагүй юу, тийм ээ.

Дахиад туршилтын санал хураалт явуулна.

8 гишүүн санал хураалтад оролцсоноор, 8 зөвшөөрч, 100 хувийн саналаар дэмжигдсэн дүн туршилтын санал хураалтаар гарч байна.

Ингээд хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн санал хураалтыг. Хэрлэн гишүүн төхөөрөмжөө сольж байна уу, тийм ээ. Эхлээд солиод суучих, ирцдээ орчих. Болчихсон уу.

Хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн саналыг, Энхтуяа гишүүн төхөөрөмжөө сольж байна уу?

Хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад оролцож зөвшөөрсөн 8, 100 хувийн саналаар хэлэлцэх асуудал батлагдлаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хуулийн төслийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар миний бие өөрөө танилцуулна.

Энд хуулийн төсөл санаачлагчийн товч танилцуулга байна. Үүнийг би уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар төсөл санаачлагчийн товч танилцуулга.

Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж, Улсын Их Хурал 1 танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж заасан. Ийнхүү Улсын Их Хурлын 126 гишүүн бүхий Улсын Их Хурлыг сонгох сонгууль 2024 оны 6 сарын 28-ны өдөр улс орон даяар явагдаж, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд байна.

Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024-2028 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэх Улсын Их Хурал үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлахаар, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй

уялдуулан хэлэлцэнэ гэж тус тус заасан хэдий ч энэ онд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил тохиосон учраас Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр завсарлуулж, дээр дурдсан хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт заасны дагуу 2020-2024 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцүүлгийн аль ч шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагчид нь буцаасан.

Иймээс хуульд хэлэлцэн шийдвэрлэх хугацаанд тусгайлан заасан зарим асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгууль явагдах жилд өмнөх Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй тохиолдолд шинээр бүрдэж бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Батсүмбэрэл, Сайнзориг, Тэмүүжин, Энхтуяа, Цогтбаатар нараас 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Төслийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцууллаа.

Төслийн үзэл баримтлалтай холбоотой асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Энэ дээрээ төхөөрөмж дээрээ өгөх юм уу, гараа өргөөд өгөх юм уу. Төхөөрөмж дээрээ асуух асуулттай гишүүд.

Ариунзаяа гишүүн. Кноп дээрээ. Ариунзаяа гишүүнээр. Ариунзаяа гишүүнээр асуултыг тасаллаа.

Асуулт асуух хугацаа дэгийн дагуу 3 минутаас илүүгүй. Нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах эрхтэй.

Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Баярбаатар дарга аа, Анхдугаар чуулганы үеэр яг энэ дэгийн тухай хууль нэлээд олон гишүүн өөрчилмөөр байна. Шинэ парламент шинэ дэгээ өөрсдөө тогтооё гэдэг асуудлыг дэвшүүлж байсан л даа.

Тэгээд бид нар түр хугацаанд хойшлуулаад нэг хэсэг ажиллаад үзье, ажлын хэсэг гаргая, дахиад дараа нь энэ хуулиа өөрчилнө гэдэг ийм зүйл заалтыг тухайн үедээ ярьж байсан. Одоо шинээр ингээд нөгөө нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар оруулж ирж байгаа нь өөрөө яах вэ, хуулийн шаардлагыг биелүүлэхэд тодорхой хэмжээнд нөгөө хугацаа нь өнгөрчихсөн байгаа учраас дэгийн тухай хуулиа өөрчлөөд, хэлэлцэх ёстой. Хуулиа хэлэлцэх ёстой. Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх юм байна гэдэг ийм агуулга орж ирж байгаа нь зөв. Үндсэндээ үүнийг дэмжиж байгаа. Зүгээр миний асуулт юу вэ гэхээр бид нар парламентад ороод ирэхээр Улсын Их Хурлын гишүүдээс тэгвэл дэгээ ер нь нэгмөсөн өөрчилбөл яасан юм бэ, яах вэ гээд нэг ийм асуулт ороод ирвэл юу гэж хариулах вэ, тийм ээ. Ер нь яаж болох вэ?

Тэгээд дээрээс нь зүгээр дэгийн тухай хуулийг зүгээр шууд гишүүд бүгдээрээ ер нь ингээд өргөн барьчихаж болдог юм байна гэдэг ийм ойлголтыг өгчих юм бол дараа нь хэдэн гишүүд нь нийлж байгаад л өөрсдөө бас байн байн ийм төслүүдийг оруулаад ирэх вий дээ.

Тэгэхээр үүн дээр хэдүүлээ бас ямар хуулийн гаргалгаа байх вэ гэдэг тал дээр жоохон дэлгэрэнгүй тайлбарлаад өгөөч.

Б.Баярбаатар: 1 дүгээрт, хэлэлцэж байгаа холбоотой асуудлыг ярих ёстой. Энэ хүрээндээ би мэдээлэл өгөхөд даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр саяын 2 асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж ирж танилцуулсан.

1 дүгээрт, төсвийн гүйцэтгэл,

2 дугаарт, хөгжлийн хөтөлбөрийн төсөл.

Ингээд дэгийн хуулиар миний саяын танилцуулгад ингээд өнгөрсөн парламент буюу хаврын ээлжит чуулганаар энэ 2 хууль батлагдсан байх ёстой байсан юм, энэ төслүүд. Гэтэл өнөөдөр ээлжит бусаар ингээд Их Хурлын даргын захирамжид орж ирж байгаа нь энэ нь өөрөө, парламент өөрөө хуулиа зөрчсөн хэлбэр лүү орчхож байгаа юм.

Тийм учраас даргын дэргэдэх зөвлөл дээр санал гаргаад өнөөдөр парламент нь, Их Хурал нь өөрөө ийм хууль зөрчдөг байж болохгүй ээ. Өнгөрсөн хугацаанд яах вэ, яаж явсныг би мэдэхгүй байна. Одоо ямар нэгэн байдлаар явж байсан ийм зүйлүүд нь байдаг байх. Тийм учраас энэ эрх зүйн зохицуулалтыг нь бид нар заавал хийх ёстой гэдэг агуулгаар өнөөдөр энэ дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн барьж байгаа.

Дараагийн нэг хуулийн зохицуулалт нь бол дараагийн нэг юу нь

бол Их Хурал өөрөө хууль тогтоох цорын ганц дээд байгууллага. Тийм учраас Их Хурал дэгээ өөрөө тогтоодог. Ийм байгаа. Энэ дээр би та нар хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаар гэдэг дээр Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1.1 дээр заасан заалтыг би уншиж өгье.

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно гэсэн ийм заалт байгаа. Жишээлбэл, өнөөдөр нэг юу гэдэг юм, тийм ээ, 1 хуулийн төслийг өргөн бариад, түүнийгээ хэлэлцэхтэй холбоотойгоор дахиж дэг өөрчлөх гэсэн ийм боломж бол хуулиар байхгүй гэж харж болно. Ер нь зүгээр Улсын Их Хурал өөрөө дэгээ тогтоодог ийм зарчимтай тохиолдолд зүгээр яг дэгээ өөрчилж гэсэн байдлаар, дэгийн хуульд өөрчлөлт оруулъя гэсэн байдлаар Улсын Их Хурлын гишүүд хэдээрээ нийлээд энэ хуулийн төслийг өргөн барих эрх нь байж байгаа. Энэ хүрээндээ өнөөдрийн энэ хуулийн төсөл өргөн баригдаад явж байгаа.

Тэгээд эцсийн шийдвэр парламент дээр гардаг учраас өргөн барих асуудлыг бид нар эцэслэн баталж байгаатай адилтгаж бодож болохгүй. Манай Байнгын хороо өнөөдөр энэ парламент 1 дүгээрт, энэ парламент өөрөө гарч байгаа шийдвэр, энэ хэлэлцэж байгаа процессууд нь өөрөө ямар нэгэн байдлаар хууль зөрчсөн байж болохгүй гэдэг ийм зүйл дээр онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой.

Дараагийн нэг зүйл бол Төрийн албаны ёс зүй, Төрийн албан хаагчийн ёс зүй, Улсын Их Хурлын гишүүдийн ёс суртахуун, ёс зүй гэсэн ийм хүрээлэлд бид нар үйл ажиллагаагаа явуулна.

Дээр нь энэ төрийн албан хаагчид, улс төрийн албан тушаалтнуудын, Улсын Их Хурлын гишүүдийн ХОМ манайд хамаарна гэсэн иймэрхүү агуулгуудаар явна. Тэгэхдээ бид энэ Байнгын хороогоо нэлээн идэвхжүүлж, нэлээн манлайлал үүсгэж, хамтарч бид нар аль болох зарчмаа барьж, хуулиа барьж, улс төржилтөө багасгаж, энэ Байнгын хороогоо бид нар өндөр түвшинд аваачих ёстой гэж үзэж байгаа. Үүнтэй манай Байнгын хорооны гишүүд санал нэгтэй байх болов уу гэж бодож байна.

Асуулт асууж, хариулт авлаа.

Уг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү?

Рэгдэл гишүүн, Баасанжаргал гишүүн 2.

Рэгдэл гишүүн санал хэлье.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа асуудлыг ерөнхийдөө уншиж танилцсан. Ямар концепц явж байгаа юм гэж. Гэхдээ зэрэг зүгээр хэлэлцэх асуудлаас өөр юм ярьж болохгүй гэдэг зөв болов чиг хэлэлцэх асуудлаас гарч болох үр дагаврыг бас ярихгүй байж болохгүй л дээ. Ариунзаяа гишүүний санаа зовж байгаа асуудалд би бас адилхан л санаа зовж байна, 1 дүгээрт.

2 дугаарт, ерөөсөө энэ хугацаандаа хэлэлцээгүй асуудлыг хуулиар зохицуулж байгаа дахиж хэлэлцдэг явдал бол Улсын Их Хурал хууль зөрчиж болно гэдгийг л цаагуураа зөвшөөрөөд байгаа асуудал шүү дээ. Заавал сонгуулийн жил гээд амждаггүй юм гэж юу байх вэ. Хэлэлцэнэ гээд л явбал хэлэлцээд явна.

Тэгээд үүнээс болоод энэ чинь 2 хуульд өөрчлөлт орох гээд байна гэдгийг бас бид нар бодмоор байгаа юм.

1 дүгээрт, төсвийн тухай хуульд заалт байна. Тэгээд тэр хуулийг өөрчлөх шаардлага гарна шүү дээ. Тэр хугацаандаа хэлэлцэнэ гэдгийг.

2 дугаарт, мэдээж дэгийн тухай хуульд. Тэгэхээр зэрэг надад 2 санал байна уучлаарай.

1 дүгээрт, энэ оруулах шаардлагагүй л юм шиг, хэлэлцэх шаардлагагүй юм шиг л санагдаад байна. Гэтэл нөгөө төсвийн гүйцэтгэлээ хэлэлцэхээс аргагүй болчихсон учраас үүнийг зөвхөн нэг удаагийн гэдэг маягаар л оруулж өгвөл Их Хурлаар хэлэлцчихмээр байна. Нэг удаагийн үйлчлэх хууль. Ийм л санал байна.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Надад бас нэг санал. Энэ нөгөө томъёолол дээр гэсэн үг. Хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг гэж байгаа. Тэгээд энэ дээр хугацаа заах уу? Хамгийн эхний ээлжит бус, ээлжит чуулган гэх юм уу, ээлжит бус гэх юм уу гэдэг тийм хугацаа тавих саналтай байна. Яг дараа нь, хэзээ гэсэн үг тийм ээ. Хамгийн анхны чуулган гэх юм уу, анхдугаар чуулган гэх юм уу.

Б.Баярбаатар: Анхдугаар чуулган асуудлаа хэлэлцээд хаагдчихсан байгаа. Яах вэ, ер нь бас тайлбар хэлэх нь зөв байх гэж бодож байна. Яг эрх зүйн талаасаа эрх зүйн зохицуулалт талаасаа бид нар яг энэ ингээд дараа дараадаа тэгээд ингээд хэлэлцэхгүй хойш нь татаад, тэгээд дараа нь нэг парламентаар хугацаа хэтэрсэн асуудлыг ийм хэлэлцдэг ийм жишиг тогтчих вий дээ гэдэг дээр зөвлөл дээр бид нар нэлээн ярилцсан юм.

Тэгээд ярилцаж ярилцаж байгаад сонгуулийн жил гэдэг үгийг оруулж ирсэн байхгүй юу. Ганицхан тэр үед. Түүнээс

бусад жилүүдэд ингээд 25 он, 26 онд бол яг тэр хуулийн хугацаандаа хэлэлцээд явна.

Рэгдэл гишүүний хэлж байгаа санал бас их зөв. Тэгэхдээ бид нар энэ эрх зүйн орчныг нь нээж өгөөд явах нь бас нөгөө талаараа зөв. Энэ асуудлуудыг заавал хэлэлцэх ёстой учраас бид нар өнөөдөр энэ дэгийн хуульдаа. Хэлэлцэх шаардлагагүй байсан бол тэгээд тэр ингээд буцаагдсан чигээрээ ингээд яваад явчих иймэрхүү байж байгаа. Энэ дээр тийм, ондоо энэ жишээлбэл хар аа, Засгийн газраас 2016 оны 06 сарын 21-ний өдөр 2015 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг 21-ний өдөр өргөн мэдүүлснийг 9 сарын 6-ны өдөр хэлэлцэж баталж байсан байгаа юм. 19 оны Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газраас 2020 оны 8 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг 8 сарын 27-ны өдөр хэлэлцэн баталж байсан байгаа. Өнгөрсөн хугацааны хууль зөрчсөн лавлагаа энэ байна шүү дээ, тийм.

Тэгэхээр иймэрхүү алдаа, дутагдлыг цаашидаа гаргахгүй. Ялангуяа сонгуулийн бус жил. Бид нар сая энэ удаадаа нэг удаа хэрэг хэрэглэгдэх ийм хууль байх юм уу, эс үгүй бол сонгуулийн жил гэдэг тодотголоор нь гаргаж ирэх нь зөв юм болов уу гэдэг байдлаар асуудалд хандаад энэ томъёоллыг Тамгын газраас бэлдэж оруулж ирсэн шүү гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Гишүүдийн саналыг чуулганы хуралдаанд танилцуулах юунд оруулна.

Одоо санал хураалтаа явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд саналаа өгнө үү.

Санал хураалтад 7 гишүүн оролцож, 87,5 хувиар дэмжигдлээ, санал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Өөрөө юу.

Байнгын хорооны дүгнэлтээ Ариунзаяа гишүүн танилцуулна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

13.58 цаг

Гишүүдэд баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ